



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 06 дугаар сарын 29 өдөр

Дугаар 62

Хэрлэн сум

LXII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 62 дугаар хуралдаан 2021 оны 06 дугаар сарын 29-ний өдрийн 10:00 цагт аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын танхимд 100 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдварын батлагдсан тохиолдол тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар санал танилцуулах,

Аймгийн ерөнхий тархвар судлаач

2.Улсын баяр наадам болохтой холбогдуулан оролцсон уяач, харваач, бөхчүүдийн буцаж ирэхэд тусгаарлалт ажиглалтад хяналт тавих талаар санал танилцуулах,

*АЗДТГ-ын Төрийн захиргааны усирдлагын хэлтэс,
Аймгийн баяр наадам зохион байгуулах комисс*

3.Эрүүл мэндийн албаны Тандалтын багийн бүтэц, ажиллах хуваарийг танилцуулах,

Аймгийн ерөнхий тархвар судлаач

4.Хөлөнбуйр сумын хяналтын цэгт шинжилгээ авч байгаа талаар мэдээлэл танилцуулах,

Эрүүл мэндийн газар



5.Аймгийн Онцгой комиссын "Зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай" 85 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх хугацааг сунгах эсэх талаар хэлэлцэх,

6.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгт ажиллах албан хаагчдын байрны асуудлын талаар хэлэлцэж шийдвэр гаргах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

7.Хэрлэн, Хөлөнбуйр сумд болон алслагдсан сумдын хяналтын цэгийн үйл ажиллагааг үргэлжлүүлэн ажиллуулах эсэх талаар хэлэлцэх,

8.Аймгийн Шуурхай штабыг Дорнод их сургууль руу шилжүүлэн байршуулж ажиллуулах эсэх талаар хэлэлцэх,

/  / М.Бадамсүрэн
/  / Хүр Г.Нармандах

9.Ачаа тээврийн хяналтын хэсгийн шатахууны зардлыг танилцуулж шийдвэрлүүлэх,

Авто тээврийн төв

10.Аж ахуйн нэгж байгууллагуудаас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийг танилцуулах,

Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газар

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

1.1.Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан А/337 тушаалын дагуу хөнгөн өвдсөн иргэдийг сум болон өрхийн Эрүүл мэндийн төвийн хяналтанд сумын Онцгой комиссын удирдлага дор эмнэлзүйн байдлыг дүгнэж гэрт нь болон сумын Эмнэлэгт эмчлэх ажлыг зохион байгуулах бэлтгэл хангах,

1.2.Сумын хэмжээнд Коронавируст халдвар /Ковид-19/-ын нөхцөл байдлыг үнэлж сумын Онцгой комиссоор хэлэлцүүлж халдварын тархалтын ямар түвшинд шилжүүлэх саналыг аймгийн Онцгой комисст ирүүлэх,

Шуурхай штабын гишүүн, ерөнхий зохицуулагч нарт:

1.3.Улаанбаатар болон голомттой бүс нутгаас ирж буй иргэд хөдөөний малчин айлд тусгаарлагдаж байгаа асуудлын талаар аймгийн Шуурхай штабын дараагийн хуралд санал танилцуулах,

1.4.Коронавируст халдвар /Ковид-19/-ын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан хот, аймаг, сум хооронд зорчих хяналт, хязгаарлалтыг чангатгах,

Хоёр.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Баяр наадам зохион байгуулах комиссын дарга Х.Бат-Эрдэнэ-д:

2.1.Улсын баяр наадам болохтой холбогдуулан Дорнод аймгаас оролцох уяач, сур болон шагайн харваач, бөхчүүдийн тусгаарлалт ажиглалтад хяналт тавих ажлын хэсэг байгуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолын төсөлд гишүүдийн саналыг тусгаж батлуулах,

Гурав.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа,



Бүсийн оношилгоо эмчилгээний төвийн захирал,

Онцгой комиссын гишүүн Д.Должин,

Сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт:

3.1.Хяналтын цэгт үүрэг гүйцэтгэж буй шинжилгээ авах ажилтан, ариутгагчийн ажлын ачааллыг хөдөлмөрийн хууль, аюулгүй ажиллагааны дүрмийн дагуу ажил, амралтын горимоор зохицуулалт хийж ажиллах,

Дөрөв.АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

 / М.Бадамсүрэн
 / Хүр Г.Нармандах

4.1.Аймгийн Онцгой комиссын "Зорчигч тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хязгаарлах тухай" 85 дугаар тогтоолын хэрэгжүүлэх хугацааг сунгах эсэх талаар сумдын Онцгой комиссоос санал авч аймгийн Онцгой комиссын дараагийн хуралд танилцуулах,

Тав.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

5.1.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгийн үйл ажиллагааг 2021 оны 07 дугаар сарын 14-ний өдрийг дуустал ажиллахад шаардагдах зардал 3,330,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн танилцуулж шийдвэрлүүлэх,

5.2.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгт томилогдон ажиллаж буй албан хаагчдын нарт халдвар хамгааллын дэглэмийг чанд мөрдөж ажиллах талаар үүрэгжүүлэн ажиллах,

5.3.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгт томилогдон ажиллаж буй албан хаагчдын нарт халдвар хамгааллын нэг удаагийн бээлий 2 хайрцаг, гар ариутгагч санитол /жижиг/ 12 ширхэг, нэг удаагийн амны хаалт 600 ширхэг, нүүрний хаалт 8 ширхэг, дархлаа дэмжих хуурай аарц 60 ширхэг, энергийн ундаа 60 ширхэг, цэвэр ус /0.5/ 80 ширхэгийг тус тус Дотоодын хүмүүнлэгийн тусламжаас Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газарт олгох,

Улаанзагалмайн хорооны дарга, Онцгой комиссын гишүүн Д.Ганболд-д:

5.4.Хэнтий аймгийн "Дэлүүн болдог" хяналтын цэгт томилогдож ажиллах албан хаагч нарын байрны зориулалтаар ашиглах монгол гэр шийдвэрлэх боломжтой эсэх талаар санал танилцуулах,

Зургаа.Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

6.1.Аймгийн Шуурхай штабын ажлын хэсгийг Дорнод их сургуулийн байр руу шилжүүлэн байршуулж ажиллуулах тухай аймгийн Онцгой комиссын тогтоолыг батлуулах,

Долоо.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

7.1.Ачаа тээврийн хяналтын хэсгийн 2021 оны 6 сард 1132 тээврийн хэрэгсэлд хяналт тавихад гарсан шатахууны зардал 3,276,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

7.2.Хот хоорондын нийтийн тээврийн хөдөлгөөнийг 2021 оны 07 дугаар сарын 14-ний өдрийг дуустал түр хязгаарлаж ажиллах,

Аймгийн Шуурхай штабын ерөнхий зохицуулагч, Ачаа тээврийн ажлын хэсгийн дарга нарт:

7.3.Ачаа тээврийн хэрэгсэл шууд буцахдаа хоосон гарсан тохиолдолд Баянтүмэн сумын хяналтын цэгээр шууд нэвтрүүлэх, хэрвээ ачаа ачсан тохиолдолд 70584647.mn цахим хуудсанд хүсэлт өгч ачаа тээврийн ажлын хэсгийн хяналтан дор нэвтрүүлэх,

 / М.Бадамсүрэн
/ Хур Г.Нармандах

Найм.Бусийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах-д:

8.1.Булган сумын Онцгой комиссоос аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтээр Мянганы зам дагуу хөдөлгөөнт хяналтын цэгээр ашиглах зорилгоор зөөврийн сууц, бусад тоног төхөөрөмж худалдан авах зардал 19,000,000 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх,

АЗДТГ-ын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Б.Алтансүх-д:

8.2.Авто зам дагуу хяналт тавих стандартын шаардлага хангасан хөдөлгөөнт хяналтын цэг, зөөврийн сууц хийлгэх загвар гаргаж танилцуулах,


Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:

8.3.Эрүүл мэндийн газраас аймгийн Онцгой комисст ирүүлсэн хүсэлтийн дагуу Эрүүл мэндийн албаны тандалтын багийн албан хэрэгцээнд ашиглах зорилгоор зөөврийн компьютер 2 ширхэгийг худалдаж авах зардал 3,920,600 төгрөгийг аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулж шийдвэрлүүлэх

АЗДТГ-ын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын гишүүн Х.Бат-Эрдэнэ-д:

8.4.Хэрлэн сумын багуудын гэрийн тусгаарлалт, ажиглалтад хяналт тавих ажлын хэсгүүдэд нэмэлтээр ажиллаж буй Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн албан хаагч нарыг сольж ажиллуулах, нэмэлтээр ажиллах төрийн албан хаагч нарын нөөцийг гаргаж танилцуулахыг тус тус үүрэг болгов.

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА, ОНЦГОЙ
КОМИССЫН ДАРГА  М.БАДАМСҮРЭН

АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН ОРЛОГЧ
ДАРГА, ХУРАНДАА  Г.НАРМАНДАХ